

**ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ
САЛБАРЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРЫН 2025 ОНЫ ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН МЭДЭЭЛЭЛ**

2026.01.15

Улаанбаатар хот

Нэг. Хяналт шалгалтын зорилго:

Хяналт, үнэлгээний үндэсний хорооны 2024 оны 02 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Салбарын хяналт шалгалтын 2025 оны төлөвлөгөөг тус үндэслэн Зам, тээврийн салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 2025 оны 04/02, 04/03, 04/04, 04/05, 04/06 дугаартай удирдамжийн дагуу авто зам, автотээвэр (усан зам), болон төмөр замын чиглэлээр ажил үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Автотээврийн тухай хууль, Авто замын тухай хууль, Төмөр замын тээврийн тухай хууль, Усан замын тээврийн тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм, журам, норм, стандартуудын мөрдөлтийн байдалд хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, цаашид авах арга хэмжээний санал боловсруулахад шалгалтын зорилго оршино.

Хоёр. Хяналт шалгалт хийсэн хугацаа:

Хяналт шалгалтыг 2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдрөөс 12 дугаар сарын 10-ны өдрүүдэд төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, урьдчилсан сэргийлэх, гүйцэтгэлийн хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн.

Гурав. Зам, тээврийн салбарын хэмжээнд хяналт шалгалтад хамрагдсан объект:

1. Төлөвлөгөөт хяналт шалгалт - 408 ААН
2. Төлөвлөгөөт бус хяналт шалгалт - 701 ААН
3. Урьдчилсан сэргийлэх хяналт шалгалт - 190 ААН
4. Гүйцэтгэлийн хяналт шалгалт - 54 ААН

Дөрөв. Зам, тээврийн салбарын хяналт шалгалт:

1. Төлөвлөгөөт хяналт шалгалт

1.1 Автотээврийн хяналтын чиглэлээр:

- СУЕБ-ийн баталсан 2025 оны 04/03 дугаартай удирдамжийн дагуу 202 иргэн, ААНБ-ын үйл ажиллагаанд төлөвлөгөөт хяналт шалгалт хийхээс 189 иргэн, ААНБ (93.5%) хамрагдсан. Хяналт шалгалтыг Зам, тээврийн яамны ТНБД-ын 2025.03.28-ны өдрийн А/74 дүгээр тушаалаар баталсан 04.1.1-04.1.17 дугаартай хяналтын хуудсаар хийж гүйцэтгэсэн. Дээрх хяналтын хуудсуудаар иргэн, ААНБ-ын үйл ажиллагааг үнэлэхэд хуулийн хэрэгжилт улсын хэмжээнд дунджаар 75 хувьтай байна. Улсын ахлах байцаагчийн акт 69, дүгнэлт 55, зөвлөмж 21 буюу нийт 145 хяналт шалгалтын баримт бичгийг үйлдэн, хүргүүлж ажилласан. Хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулахаар улсын (ахлах) байцаагчийн 1988 заалт бүхий 64 албан шаардлагыг хүргүүлж, хэрэгжилт 86 хувьтай. Хяналт шалгалтад хамрагдсан 189 ААНБ-аас эрсдэлийн түвшин буурсан 65 объект байна.
- Жилийн эцсийн байдлаар 109 зөрчлийн хэрэг шийдвэрлэж ажилласан. Үүнээс 90 зөрчлийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэж, 19 зөрчилд зөрчлийн хэрэг нээсэн. Нийт 39,900.00 мянган төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, 100 хувь барагдуулсан.

1.2 Авто замын хяналтын чиглэлээр:

- СУЕБ-ийн баталсан 2025 оны 04/03 дугаартай удирдамжийн дагуу 191 аж ахуй нэгж, иргэний үйл ажиллагаанд төлөвлөгөөт хяналт шалгалт хийсэн. Хяналт шалгалтыг Зам,

тээврийн яамны ТНБД-ын 2025.03.28-ны өдрийн А/74 дүгээр тушаалаар баталсан 04.2.1-04.2.9 дугаартай хяналтын хуудсаар хийж гүйцэтгэсэн. Шалгалтад хамрагдсан объектуудаас их эрсдэлтэй 49, дунд эрсдэлтэй 142 үнэлэгдсэн байна. Хяналт шалгалтаар нийт 572 зөрчил, дутагдал илэрснээс 452 буюу 79 хувийг арилгуулж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулахаар 80 газарт улсын (ахлах) байцаагчийн 470 заалт бүхий хугацаатай албан шаардлага, улсын ахлах байцаагчийн дүгнэлт 63, зөвлөмж 27 хүргүүлсэн.

- Авто замын хяналтын чиглэлээр шалгалтад хамрагдсан объектын хууль сахин мөрдөлтийг төлөвлөгөөт шалгалтаар 63.0 хувь байсныг 76.0 хувьд хүргэж гүйцэтгэлийн хяналтаар түвшинг 14.0 хүртэл хувиар нэмэгдүүлсэн.
- Гүйцэтгэлийн хяналтыг 47 объектод хийснээс 25 нь эрсдэлийн түвшин буурсан, 22 объектын эрсдэл үүсэх магадлалын хувь буурсан дүнтэй байна.
- Жилийн эцсийн байдлаар 33 зөрчлийн хэрэг шийдвэрлэж ажилласан. Үүнээс 13 зөрчлийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэж, 18 зөрчилд зөрчлийн хэрэг нээсэн, татгалзсан 1, хэрэгсэхгүй болгосон 1. Нийт 26,650.00 мянган төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, 100 хувь барагдуулсан.

1.3 Төмөр замын хяналтын чиглэлээр:

- СУЕБ-ийн баталсан 2025 оны 04/17, 04/31, 04/32 дугаартай удирдамжийн дагуу гурван төмөр замын байгууллагын 3 объектод, мөн Төмөр замын газрын Төмөр замын салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 25/04-13-03/141/03, 08, 006/19, 006/21 дугаартай удирдамжийн дагуу 3 объект буюу нийт 6 объектод төлөвлөгөөт хяналт шалгалт хийж, нийт 85 зөрчил илрүүлж, хугацаатай албан шаардлага өгсөн.

1.4 Усан замын тээврийн хяналтын чиглэлээр:

- СУЕБ-ийн баталсан 2025 оны 04/03 дугаартай удирдамжийн дагуу усан замын тээврийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй нийт 23 иргэн, аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт хяналт шалгалт хийхээс 22 иргэн, ААН (95.6%) хамрагдсан.
- Хяналт шалгалтыг Зам, тээврийн яамны ТНБД-ын 2025.03.28-ны өдрийн А/74 дүгээр тушаалаар баталсан 04.4.1 дугаартай “усан замын тээврийн аюулгүй байдлыг шалгах хяналтын хуудас”-аар үнэлсэн.
- Хяналт шалгалтаар илэрсэн 144 зөрчил илрүүлж, зөрчил гаргасан 14 аж ахуйн нэгж, иргэнд 135 заалт бүхий улсын (ахлах) байцаагчийн албан шаардлага, 8 улсын ахлах байцаагчийн актыг өгч биелэлтийг хангуулан ажилласан ба үүрэг даалгаврын биелэлт 82.9%-тай байна.
- Шалгалтын явцад холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн 5 аж ахуйн нэгж, 4 иргэнд Зөрчлийн тухай хуулийн дагуу 950.0 мянган төгрөгийн торгууль ногдуулсан. Хяналт шалгалтад хамрагдсан ААН, иргэдэд сургалтыг зохион байгуулан мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

2. Төлөвлөгөөт бус хяналт шалгалт

2.1 Автотээврийн хяналтын чиглэлээр:

- СУЕБ-ийн баталсан 2025 оны 04/04 дугаартай удирдамжийн дагуу Ховд аймгийн Булган сумын "Алсын саруул зам" ХХК-ийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийхэд Их эрсдэлтэй үнэлэгдсэн.
- Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5² дугаар зүйлийн 5^{2.1} дэх заалтыг үндэслэн ЗТС-ын шуурхай хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын дагуу СУЕБ-ийн баталсан 2025 оны 04/18 дугаартай удирдамжийн хүрээнд тээврийн хэрэгсэлд үйлдвэрлэгчээс тогтоосноос өөр замын хөдөлгөөний аюулгүй байдалд нөлөөлөх хурц тусгал бүхий гэрэлтүүлэх хүч өндөртэй стандарт бус хол, ойрын гэрэл суурилуулсан болон гадна талын гэрэлтүүлэх хэрэгсэл бүрэн бус замын хөдөлгөөнд оролцож байгаа байдалд 2025.03.26-28-ны өдрүүдэд Дорноговь, Говьсүмбэр аймгийн нутаг дэвсгэрээр дамжин өнгөрч байгаа 95 автотээврийн хэрэгсэлд хяналт шалгалт хийсэн.

- Баянчандмань хурд хоршооны хот хоорондын зорчигч тээврийн үйлчилгээ эрхэлж буй үйл ажиллагаанд шалгалт хийсэн. Илэрсэн зөрчлийг арилгуулахаар 11 заалт бүхий 2025 орны 04-00-01/004/12 дугаартай улсын ахлах байцаагчийн албан шаардлагыг хүргүүлж, Зөрчлийн тухай хуулийн дагуу 1.0 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээг авч, 100 хувь барагдуулав.
- Иргэн Д.Отгонсүхээс ирүүлсэн гомдлын дагуу СУЕБ-ийн баталсан 2025 оны 04/02 дугаартай удирдамжийн дагуу шалгалт хийж, Жиу лун сян хө ХХК-д Зөрчлийн тухай хуулийн 14.6 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн үндэслэн 1.5 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, 100 хувь барагдуулав.
- ЗТС-ын 2025.05.27-ны өдөр өгсөн үүрэг даалгаврын дагуу СУЕБ-ийн баталсан 2025 оны 04/36 дугаартай төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх удирдамжийн дагуу 2025.06.04-08-ны өдрүүдэд Говьсүмбэр, Дорноговь аймаг, Замын-Үүд сумын нутаг дэвсгэрээр даац хэтрүүлэн ачаа тээвэрлэлт хийж байсан “Мөнхийн баян гал” ХХК, “МАК евро цемент” ХХК, “Монцемент билдинг материалс” ХХК, “Хүдэр эрдэнэ” ХХК, “Хар занар” ХХК-д улсын ахлах байцаагчийн 5 акт, 3 албан шаардлага хүргүүлэн биелэлтэд хяналт тавин ажилласан.
- Иргэн, ААН, байгууллагаас ирсэн өргөдөл гомдол, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын дагуу СУЕБ-ийн баталсан 2025 оны 04/02 дугаартай удирдамжийн дагуу Мөнхийн баян гал ХХК, Дундговь аймгийн Баянжаргалан сумын уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэлт, Сунхунголд ХХК, Галзоо хан ХХК, Бор өндөр уул ХХК компаниудад хяналт шалгалтад хамруулж шалгалтын явцад аж ахуйн нэгжүүдийн удирдлага, инженер техникийн ажилтан, тээвэрлэгч жолооч нарт мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар 2 заалттай 1 улсын ахлах байцаагчийн акт, 11 заалттай 2 албан шаардлага хүргүүлэн ажиллаж 3 хуулийн этгээдэд нийт 6.0 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч ажилласан.
- ЗТС-ын 2025.01.09-ний өдрийн А/03 дугаартай тушаалаар баталсан “Улс хоорондын ачаа тээврийн “С” төрлийн зорчих зөвшөөрлийн бичиг олгох, ашиглах, хяналт тавих үйл ажиллагаанд баримтлах удирдамж”-ийн хүрээнд СУЕБ-ийн баталсан 2025 оны 04/24 дугаартай төлөвлөгөөт бус хяналт хийх удирдамжийн дагуу авто замын хилийн 9 боомт тус бүрээр улс хоорондын байнгын ачаа тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэгч 638 аж ахуйн нэгж болон 25705 тээврийн хэрэгсэлд хяналт шалгалт хийсэн. Үүнээс их эрсдэлтэй 281, дунд эрсдэлтэй 257, бага эрсдэлтэй 82 аж ахуй нэгж байна.
- СУЕБ-ийн баталсан 2025 оны 04/21 дугаартай удирдамжийн дагуу “Дашваанжил” ХХК-ийн Арвайхээр сум дахь АХЦС-12 салбар, Горгаз ХХК-ийн Арвайхээр сум дахь АХЦС-23 салбар, Горгаз ХХК-ийн Хархорин сум дахь АХЦС-24 салбаруудын баллонтой шахсан хий тээвэрлэх үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж 3 албан шаардлага хүргүүлсэн. 2025 оны эхний хагас жилийн байдлаар СУЕБ-ийн баталсан 2025 оны 04/21 дугаартай төлөвлөгөөт бус шалгалтын удирдамжийн хүрээнд аюултай ачаа тээвэрлэгч 9 ААН-ийн 10 тээврийн хэрэгсэлд шалгалт хийж, 6 аж ахуй нэгжид 32 заалттай улсын байцаагчийн хугацаатай албан шаардлага хүргүүлэн биелэлтэд хяналт тавин ажилласан.
- Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын 5-р багийн иргэн Г.Одгэрэлээс ирүүлсэн өргөдлийн дагуу “Тун гуан майнз констракшн монголиа” ХХК-д төлөвлөгөөт бус шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулахаар 12 заалттай албан шаардлага хүргүүлж, Зөрчлийн тухай хуулийн 14.6-р зүйлийн 3-д заасны дагуу 1.5 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч 100 хувь барагдуулсан.
- Алтан жолоо найзуудын зам хоршооноос 09 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлт болон СУЕБ-ийн баталсан 2025 оны 04/02 дугаартай удирдамжийн дагуу Баянчандмань хурд хоршооны хот хоорондын зорчигч тээврийн үйлчилгээ эрхэлж буй үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус шалгалт хийсэн. Шалгалтын явцад автотээврийн хэрэгслийн ашиглалт, үйлчилгээнд ашиглагдаж буй 13 дунд, бага багтаамжийн автобусны техникийн бүрэн бүтэн байдлыг шалгасан. Илэрсэн зөрчлийг арилгуулахаар 11 заалт бүхий 04-00-01/004/12 дугаартай улсын ахлах байцаагчийн албан шаардлагыг хүргүүлж, Зөрчлийн

тухай хуулийн дагуу 1.0 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээг авч, 100 хувь барагдуулав.

- Иргэн Ш.Эрдэнэпил, Б.Сүхбаатар, С.Ганбаатар, Д.Адъяасүрэн, Д.Чулуунбаатар, Б.Нэргүй, Б.Ганпүрэв, Д.Мөнхтогтох нараас ирүүлсэн гомдолтой танилцаж, ЗТЯ-ны 2025 оны 11/2352 тоот албан бичгээр хариуг хүргүүлэв.
- СУЕБ-ийн баталсан 2025 оны 04/02 дугаартай удирдамжийн дагуу Булган сумын Тохижилт үйлчилгээний анги, Залман хангай хоршоо, Орхон аймгийн Хот тохижуулах газар УТҮГ, ББ-ОД ХХК, Эрдэнэт арслан ХХК, Автомастер төв ХХК зэрэг 6 аж ахуйн нэгж, байгууллагад хяналт шалгалт хийж, тусгай зөвшөөрөлгүйгээр зорчигч тээврийн үйлчилгээ эрхэлж байгаа зөрчил илэрсэн тул “Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээг зогсоох тухай” 28 заалт бүхий 7 актыг гаргаж, хүргүүлэв. Албан шаардлагын биелэлт 83 хувьтай биелсэн байна.

2.2 Авто замын хяналтын чиглэлээр:

- СУЕБ-ийн 2025 оны 04/20 дугаартай удирдамжаар Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дахь үйл ажиллагаа явуулж байгаа “Мөнхийн баян гал” ХХК-ийн үйлдвэрээс тээвэрлэлт гүйцэтгэж байгаа авто замын ашиглалтын нөхцөл байдал, засвар арчлалт болон тээвэрлэлтийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, “Мөнхийн баян гал” ХХК-д 04-00-02/007/11 дугаартай албан шаардлагыг өгсөн.
- ТНБД-ын 2025.03.30-ны удирдамжаар Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэдэг авто замын нөхцөл байдал, тээвэрлэлтийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг гүйцэтгэж, холбогдох ажлыг зохион байгуулах талаар улсын ахлах байцаагчийн 04-00-02/005,007/10 дугаартай албан шаардлагыг 2025.04.25-ны 11/1916 тоот албан бичгийн хамт ЗД-д хүргүүлсэн. Шалгалтын хэрэгжилтэд хяналт тавьж хамтран ажиллах талаар АҮЭБЯ, БОУУӨЯ-нд 2025.04.29-ний 11/1948, 11/1949 болон цаашид анхаарах асуудлын талаар Дундговь аймгийн ЗДТГ-т 2025.04.29-ний 11/1951 дугаартай албан бичгийг тус тус хүргүүлж ажилласан.
- ТНБД-ын 2025.05.12-ны А/120 дугаартай тушаал, СУЕБ-ийн 2025.05.08-ны 04/30, 04/03 дугаартай удирдамжаар Харганатын уурхайгаас Ховд аймгийн Мянгад сумаар дайрч Булган сумын Цоохор нуур хүртэлх төмрийн хүдрийн тээвэрлэлтийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, 04-00-02/007/14 тоот актаар “Эй Эл Жи Ти” ХХК-ийн тээвэрлэлтийн үйл ажиллагааг түр зогсоосон, улсын чанартай авто замаар зорчиж буй хүнд даацын тээврийн хэрэгслийн үйл ажиллагаанд Зөрчлийн тухай хуулийн дагуу захиргааны арга хэмжээг авч ажилласан.
- А0305 дугаартай Ховд-Өлгий, А14 дугаартай Манхан-Булган боомт чиглэлийн авто замаар зорчиж буй хүнд даацын тээврийн хэрэгслийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, Шалгалтаар илэрсэн дутагдлыг арилгуулахаар “АЗ3АН” ТӨХК-д 04-00-02/007/32 дугаартай албан шаардлага өгч, хэрэгжилтийг хангуулах үүрэг даалгавар өгсөн.
- ЗТС-аас өгсөн үүрэг даалгавар, ТНБД-ын 2025.05.30-ны А/141 дугаартай тушаал, СУЕБ-ийн 2025.05.30-ны 04/36 дугаартай удирдамжаар Говьсүмбэр, Дорноговь аймгийн нутаг дэвсгэрээр дамжин ачаа тээвэрлэлтийн үйл ажиллагаа стандартын шаардлага хангаж байгаа эсэхэд хяналт шалгалт хийж, хүдэр, цемент, хайрга нийлүүлэгч ААНБ-д 04-00-02/011/39, 04-00-02/011/40, 04-00-02/007/41 дугаартай албан шаардлага хүргүүлж, тээвэрлэлтийн үйл ажиллагааг түр хугацаагаар 04-00-02/007/16, 04-00-01/003/18, 04-00-01/003/19, 04-00-01/003/20, 04-00-01/003/21 дугаартай актаар зогсоосон бөгөөд үүрэг даалгаврын биелэлтийг хэрэгжилтийг хангуулсан тул “Мөнхийн баян гал” ХХК-ийг тээвэрлэлтийн үйл ажиллагааг 2025.06.13-ны 04-00-02/007/28 дугаартай актаар сэргээсэн.
- ЗТС-аас өгсөн чиглэлийн дагуу СУЕБ-ийн баталсан 2025 оны 04/06 дугаартай удирдамжийн дагуу Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Эргэл, Агаруут багийн иргэд, малчдаас утсаар болон газар дээр нь мэдэгдсэн мэдээллийн дагуу “Түмэн айл инвест” ХХК-ийн Довцог худаг уурхайгаас тээвэрлэлт гүйцэтгэж буй авто зам, замын байгууламжийн ашиглалтын нөхцөл засвар арчлалтад дутагдлыг арилгуулахаар улсын ахлах байцаагчийн 04-00-02/008/29 албан шаардлагыг өгсөн.

- ЗТС-аас өгсөн үүрэг даалгавар, ТНБД-ын 2025.08.07-ны А/212 дугаартай тушаалын дагуу үерийн улмаас сэтэрсэн Т-01 дугаартай Ухаахудаг-Гашуунсухайт чиглэлийн тусгай зориулалтын авто замын эвдрэлийн нөхцөл байдалтай газар дээр нь танилцаж, нүүрс тээвэрлэлтийн үйл ажиллагааг яаралтай сэргээх холбогдох арга хэмжээг авч ажилласан. “Тал нутгийн хөгжлийн зам” ХХК-ийн 2025 оны 132/25 тоот албан бичгийн хүсэлтийг үндэслэн Өмнөговь аймгийн Цагаанхад суурьшлын бүс дэх “Оюутолгой” ХХК-ийн авто замын уулзвараас Гашуунсухайт боомт чиглэлд “Смарт эко транс” ХХК-ийн хэрэгжүүлж буй авто замыг газар дээр очиж хяналт шалгалт хийж, “Тал нутгийн хөгжлийн зам” ХХК-д 11/3930 дугаартай албан бичгээр хариуг хүргүүлсэн.
- ТНБД-ын 2025.08.11-ний А/214 дугаартай тушаалаар Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутагт орших (Хар өндрийн уурхай) ашигт малтмалын орд газраас Говьсүмбэр аймгийн Чойр өртөөний чиглэлд хийгдэж буй уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэлт, авто замын нөхцөл байдалд хяналт шалгалт хийж, “Тайшин Девелопмент” ХХК-д Дундговь аймгийн Баянжаргалан сумын нутаг дэвсгэрт байрлах “Эрээн”-ий төмрийн хүдрийн орд газраас Говьсүмбэр аймгийн Чойр төмөр замын өртөө хүртэлх төмрийн хүдэр тээвэрлэлтийг илэрсэн зөрчлийг арилгах хүртэл түр хугацаагаар зогсоох тухай” 04-00-02/011/41 дугаартай акт тогтоож, мөн “Илэрсэн дутагдлыг арилгуулах тухай” 04-00-02/011/86 дугаартай хугацаатай албан шаардлага өгч, хэрэгжилтийг хангуулах үүрэг өгсөн. Хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох арга хэмжээг авч ажиллах талаар Дундговь болон Говьсүмбэр аймгийн ЗДТГ-т 11/3870, 11/3871 дугаартай албан бичгийг хүргүүлсэн. Албан шаардлагын хэрэгжилт 90 хувьтай.

2.3 Төмөр замын хяналтын чиглэлээр:

- СУЕБ-ийн баталсан 2025.01.13-ны 04/01 дугаартай удирдамжийн дагуу Ник ХК, Мах импекс ХК-д хяналт шалгалт хийж, дүгнэлт гаргасан.
- СУЕБ-ийн баталсан 2025.01.31-ний 04/09 дугаартай удирдамжийн дагуу УБТЗ ХНН-ийн хүүхдийн төмөр замд өөрийн хүсэлтийн дагуу хяналт шалгалт хийж, дүгнэлт гаргасан.
- СУЕБ-ийн баталсан 2025.01.31-ний 04/10 дугаартай удирдамжийн дагуу УБТЗ ХНН-ийн дохиолол холбооны төсөлд өөрийн хүсэлтийн дагуу хяналт шалгалт хийж, дүгнэлт гаргасан.
- СУЕБ-ийн баталсан 2025.01.31-ний 04/11 дугаартай удирдамжийн дагуу Дархан таван нуур ХХК-д өөрийн хүсэлтийн дагуу хяналт шалгалт хийж, дүгнэлт гаргасан.
- СУЕБ-ийн баталсан 2025.02.15-ны 04/12 дугаартай удирдамжийн дагуу Юу ти си ХХК-д өөрийн хүсэлтийн дагуу хяналт шалгалт хийж, дүгнэлт гаргасан.
- СУЕБ-ийн баталсан 2025.03.12-ны 04/13 дугаартай удирдамжийн дагуу Милл хаус ХХК-д өөрийн хүсэлтийн дагуу хяналт шалгалт хийж, дүгнэлт гаргасан.
- СУЕБ-ийн баталсан 2025.03.14-ний 04/14 дугаартай удирдамжийн дагуу Агро волд холдинг ХХК-д өөрийн хүсэлтийн дагуу хяналт шалгалт хийж, дүгнэлт гаргасан.
- СУЕБ-ийн баталсан 2025.03.17-ны 04/16 дугаартай удирдамжийн дагуу Нави стар транс ХХК-д өөрийн хүсэлтийн дагуу хяналт шалгалт хийж, дүгнэлт гаргасан.
- СУЕБ-ийн баталсан 2025.03.24-ны 04/19 дугаартай удирдамжийн дагуу Түмэн айл көүл ХХК-д өөрийн хүсэлтийн дагуу хяналт шалгалт хийж, дүгнэлт гаргасан.
- СУЕБ-ийн баталсан 2025.04.03-ны 04/22 дугаартай удирдамжийн дагуу Магнай трэйд ХХК, Химийн шингэн ХХК-д өөрийн хүсэлтийн дагуу хяналт шалгалт хийж, дүгнэлт гаргасан.
- СУЕБ-ийн баталсан 2025.04.23-ны 04/23 дугаартай удирдамжийн дагуу Гор газ ХХК-д өөрийн хүсэлтийн дагуу хяналт шалгалт хийж, дүгнэлт гаргасан.
- СУЕБ-ийн баталсан 2025.04.15-ны 04/25 дугаартай удирдамжийн дагуу Ант смарт систем ХХК-д өөрийн хүсэлтийн дагуу хяналт шалгалт хийж, дүгнэлт гаргасан.
- СУЕБ-ийн баталсан 2025.04.17-ны 04/26 дугаартай удирдамжийн дагуу Шууд хур ХХК-д өөрийн хүсэлтийн дагуу хяналт шалгалт хийж, дүгнэлт гаргасан.
- СУЕБ-ийн баталсан 2025.04.24-ний 04/27 дугаартай удирдамжийн дагуу Цахим ундром мод ХХК-д өөрийн хүсэлтийн дагуу хяналт шалгалт хийж, дүгнэлт гаргасан.

- СУЕБ-ийн баталсан 2025.04.28-ны 04/28 дугаартай удирдамжийн дагуу Ти энд эй ХХК-д өөрийн хүсэлтийн дагуу хяналт шалгалт хийж, дүгнэлт гаргасан.
- СУЕБ-ийн баталсан 2025.05.28-ны 04/35 дугаартай удирдамжийн дагуу Жинсийн орой ХХК-д өөрийн хүсэлтийн дагуу хяналт шалгалт хийж, дүгнэлт гаргасан.
- СУЕБ-ийн баталсан 2025.05.28-ны 04/36 дугаартай удирдамжийн дагуу Перфектрайл ХХК-д өөрийн хүсэлтийн дагуу хяналт шалгалт хийж, дүгнэлт гаргасан.
- СУЕБ-ийн баталсан 2025.06.30-ны 04/38 дугаартай удирдамжийн дагуу Рейлвэй күүл менежмент ХХК-д өөрийн хүсэлтийн дагуу хяналт шалгалт хийж, дүгнэлт гаргасан.
- Нийт төмөр замын чиглэлээр 18 төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийсэн, үүрэг даалгаврын биелэлт 82 хувьтай.

3. Урьдчилсан хяналт шалгалт

3.1 Автотээврийн хяналтын чиглэлээр:

- Автотээврийн хяналтын чиглэлээр нийт 107 объектыг хамруулан урьдчилан сэргийлэх шалгалт хийсэн. Шалгалтаар 507 зөрчлийг илрүүлж 426 буюу 84.0%-ийг арилгуулж ажилласан.

3.2 Авто замын хяналтын чиглэлээр:

- Авто замын хяналтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 65 ААН, иргэдийг хамруулан хяналт шалгалтыг хийсэн. Хяналт шалгалтаар 47 объектод хяналт хийж, 174 зөрчил илрүүлж, 1351 буюу 77.58 хувийг арилгуулж, илэрсэн зөрчил дутагдалд Зөрчлийн тухай хуулийн дагуу арга хэмжээ авч ажилласан байна.

3.3 Төмөр замын хяналтын чиглэлээр:

- Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 2025 оны удирдамжийн дагуу 6 газарт урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж гүйцэтгэв. Шалгалтаар нийт 15 зөрчил илрүүлж, түүнийг арилгах зөвлөмж хүргүүлсэн.

3.4 Усан замын тээврийн хяналтын чиглэлээр:

- СУЕБ-ийн баталсан 2025 оны “Урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай” 04/04 дугаартай удирдамжийн дагуу 39 аж ахуйн нэгж, иргэдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж гүйцэтгэв. Шалгалтын явцад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, 107 зөрчил илрүүлж, зөрчил гаргасан 12 аж ахуйн нэгж, иргэнд 66 заалттай улсын /ахлах/ байцаагчийн албан шаардлага, 41 заалттай 14 акт гарган хүргүүлж, биелэлтэд хяналт тавин ажилласан ба өгсөн үүрэг даалгаврын биелэлт 82.5 хувьтай байна.

4. Гүйцэтгэлийн хяналт шалгалт

4.1 Автотээврийн хяналтын чиглэлээр:

- 2025.09.15-ны өдөр “Цэн шанд эрдэнэ” ХХК-ийн тээврийн хэрэгслийн улсын дугаарын үйлдвэрт гүйцэтгэлийн хяналт шалгалт хийхэд хууль сахин мөрдөлт 88.8 хувь буюу 13.3 хувиар өссөн, эрсдэл үүсэх магадлал 25.1 хувь буюу 13.3 хувиар буурсан байна.
- 2025.09.17-ны өдөр “Эхлэл-Ургац” ХХК-ийн тээврийн хэрэгслийн улсын дугаарын үйлдвэрт гүйцэтгэлийн хяналт шалгалт хийхэд хууль сахин мөрдөлт 95.6 хувь буюу 32.6 хувиар өссөн, эрсдэл үүсэх магадлал 1.5 хувь буюу 65.5 хувиар буурсан, мөн “Рэс” ХХК-ийн хууль сахин мөрдөлт 84.7 хувь буюу 17.46 хувиар өссөн, эрсдэл үүсэх магадлал 7.39 хувь буюу 54.1 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй үнэлэгдсэн. Албан шаардлагын биелэлт 80 хувьтай байна.
- Даланзадгад зорчигч тээвэр ОНӨААТҮГ-т Өмнөговь аймгийн Засаг даргын 2025.06.02-ны өдрийн А/882 тоот захирамжаар “Орон нутгийн нийтийн зорчигч тээврийн үйлчилгээг эрхлэх 2025/0001 дугаартай тусгай зөвшөөрөл”-ийг олгож, зөрчлийг арилгасан тул 04-

00-01/004/17 дугаартай улсын ахлах байцаагчийн актаар нийтийн зорчигч тээврийн үйлчилгээг сэргээсэн ба үүний үр дүнд хуулийн хэрэгжилт бүрэн хангагдав.

- Бид анд нар ХХК улсын ахлах байцаагчийн албан шаардлагаар өгөгдсөн үүрэг даалгаврын дагуу битүү зогсоол, угаалгын газрыг шинээр барьж байгуулсан, мэргэжлийн инженер техникийн ажилтнаар хангагдсан, 4 тээврийн хэрэгслийн салхины шил сольсон, 10 тээврийн хэрэгслийн жолоочийн болон зорчигчийн суудлыг чийг татахгүй материалаар шинээр бүрсэн зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна. Үүний үр дүнд хууль сахин мөрдөлт 22.6 хувь өссөн, 28.5 хувиар эрсдэл буурч бага эрсдэлтэй дүгнэгдэв. Албан шаардлагын биелэлт 81.8 хувьтай байна.
- Шуудан тээх ХХК улсын ахлах байцаагчийн албан шаардлагаар өгөгдсөн үүрэг даалгаврын дагуу битүү зогсоолыг телекамер, галын дохиолол, галын аюулгүйн багаж хэрэгслээр бүрэн тоноглогсон, автотээврийн хэрэгсэл бүрийг хүүхдийн суудалтай болгосон, зорчигчийн эрх, үүргийг сурталчилсан, байгуулсан, техникийн бэлэн байдал, парк болон суудал ашиглалтын коэффициент гаргасан зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн ба албан шаардлагын биелэлт 81.2 хувьтай. Үүний үр дүнд хууль сахин мөрдөлт 24.2 хувь өсөж, эрсдэл 21.2 хувиар буурч дунд эрсдэлээс бага эрсдэлтэй дүгнэгдэв.
- Тахилт транс ХХК улсын ахлах байцаагчийн албан шаардлагаар өгөгдсөн үүрэг даалгаврын дагуу битүү зогсоолыг телекамер, галын дохиолол, галын аюулгүйн багаж хэрэгслээр бүрэн тоноглогсон, шар цагаан зураасны тэмдэглэгээгээр тэмдэглэсэн, автотээврийн хэрэгсэл бүрийг хүүхдийн суудалтай болгосон, жолооч нарыг эрүүл мэндийн үзлэгт бүрэн хамруулсан, зорчигчийн эрх, үүргийг сурталчилсан, байгуулсан, техникийн бэлэн байдал, парк болон суудал ашиглалтын коэффициент гаргасан, дотоод хяналт шалгалтын журмыг боловсруулсан зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн ба албан шаардлагын 81.2 хувьтай дүгнэгдэв. Үүний үр дүнд хууль сахин мөрдөлт 29.2 хувь өсөж, эрсдэл 25.7 хувиар буурч дунд эрсдэлээс бага эрсдэлтэй дүгнэгдэв. Гүйцэтгэлийн шалгалтаар дээрх аж ахуйн нэгжүүдийн эрсдэл буурч бага эрсдэлтэй болсноор тээвэрлэлтийн болон техникийн аюулгүй байдал хангагдаж, зорчигчийг аюул осолгүй тээвэрлэх нөхцөл бүрдсэн.
- Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах хүртэл түр зогссон улс хоорондын ачаа тээвэрлэгч Булган гол транс ХХК, Бадамлаххөшөөт ХХК, Алтайн даваа ХХК, Баянголын хүлгүүд ХХК зэрэг хот хоорондын зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгч Цастын хүлгүүд ХХК, орон нутгийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэгч Ховд аймгийн Жаргалант сумын ЗДТГ, Батхөсөгтөн ХХК, “Булган сумын Тохижилт үйлчилгээний анги” ХХК, “Булган жолоо” ХХК, “Залман хангай” хоршоо, Орхон аймгийн “Хот тохижуулах газар” УТҮГ, “ББ-ОД” ХХК зэрэг 10 аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу гүйцэтгэлийн шалгалт хийж, зөрчлийг арилгасан тул 04-00-01/004/17, 52-57, 61, 63-67 тоот актаар тээвэрлэлтийн үйл ажиллагааг сэргээсэн. Үүний үр дүнд авто зогсоолыг гэрэлтүүлэг болон телекамераар тоноглож, галын аюулгүйн багаж хэрэгслээр тоноглогсон, хөдөлгөөний чиглэл болон галын аюулын үеийн хөдөлгөөний бүдүүвч зургийг орох, гарах хаалганд ил байрлуулсан, автотээврийн хэрэгсэл байрлах зогсоолын байрлалыг цагаан зураасаар тэмдэглэсэн, орох гарах хаалгыг тусад нь хийж, технологийн урсгалыг хангасан, засварын байрыг шинээр барьж ашиглалтад оруулсан, мэргэжлийн инженер техникийн ажилтан, эмчээр хангагдсан, аюултай хог хаягдал цуглуулах тээвэрлэх ажлыг шуурхай зохион байгуулсан, автомашин ашиглалттай холбоотой асуудлыг хянан шийдвэрлэж байх үүрэг бүхий техникийн комисс /зөвлөл/-ийг байгуулж, ажиллах журмыг боловсруулж, жолоочийн хөдөлмөр амралтын горимыг мөрдүүлсэн зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэснээр автотээврийн хэрэгслийн ашиглалт сайжирч, техникийн аюулгүй байдал хангагдсан. Албан шаардлагын биелэлт 83.5 хувьтай биелсэн.

4.2 Авто замын хяналтын чиглэлээр:

- ТНБД-ын 2025.05.12-ны А/120 дугаартай тушаал, СУЕБ-ийн баталсан 2025 оны 04/30 дугаартай удирдамжаар Баян-Өлгий аймгийн Өлгий хотыг тойрон гарах 18.82 км авто

зам, гүүрийн барилгын ажлын Багц CW3 хэсэг 11.8 км авто зам, 4.5х4.65м нүхэн гарц гүүр (“Эйч Кэй Би интернэшнл холдинг” ХХК-д 04-00-02/007/34 дугаартай албан шаардлага)

- Улсын чанартай А0305 дугаартай авто замаас Ховд аймгийн Эрдэнэбүрэн сум хүртэлх 19.776 км хатуу хучилттай авто зам; (“Ди Вай Кэй Би” ХХК-д 04-00-02/011/26 дугаартай албан шаардлага)
- Ховд аймгийн Ховд сум хүртэлх 18.755 км хатуу хучилттай авто зам; (“Ди Вай Кэй Би” ХХК-д 04-00-02/011/28 дугаартай албан шаардлага)
- Ховд аймгийн Дөргөн сумын төвийн 1.1 км хатуу хучилттай авто зам; (“МАЗ” ХХК-д 04-00-02/007/14 дугаартай албан шаардлага)
- ЗТ-ийн Сайдын 2025.05.27-нд өгсөн үүрэг даалгавар, ТНБД-ын 2025.05.30-ны А/141 дугаартай тушаал, СУЕБ-ийн 2025.05.30-ны 04/36 дугаартай удирдамжаар Говьсүмбэр, Дорноговь, Төв аймгийн нутаг дэвсгэрээр дамжин ачаа тээвэрлэлтийн үйл ажиллагаа стандартын шаардлага хангаж байгаа эсэхэд хяналт шалгалт хийж, стандартын хэрэгжилтийг хангуулсан тул “Мөнхийн баян гал” ХХК, “МАК Евро цемент” ХХК, “Монцемент билдинг материалс” ХХК-ийг тээвэрлэлтийн үйл ажиллагааг 2025.06 сард 3 актаар сэргээсэн.
- Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутаг дахь Элдэв багаас төмөр замын 25 дугаар зөрлөг хүртэлх авто замын ашиглалтын байдалд өгсөн үүрэг даалгаврын гүйцэтгэлд, 2025 онд эхлүүлсэн урсгал засварын ажлын явцад урьдчилан сэргийлэх шалгалтыг гүйцэтгэж, 04-00-02/007/15 дугаартай зөвлөмжийг хүргүүлсний үр дүнд ЗТ-ийн сайдын 2025 оны 9 сард тээвэрчдтэй уулзах үед тус авто замын засварын ажлыг дуусгасан. Албан шаардлагын хэрэгжилт 80 хувьтай.

4.3 Усан замын тээврийн хяналтын чиглэлээр:

- Усан замын тээврийн үйлчилгээ эрхлэгч 26 аж ахуйн нэгж, иргэний үйл ажиллагаанд гүйцэтгэлийн шалгалт хийхэд өмнөх шалгалтаар илэрсэн 167 зөрчлөөс 144 зөрчлийг арилгаж, улсын (ахлах) байцаагчийн хугацаатай өгсөн үүрэг даалгаврын биелэлт 89.2 хувьтай биелэгдсэн байна. Зөрчлийг арилгаагүй 9 иргэнд 975.0 мян.төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, 100 хувь барагдуулсан. 15 аж ахуйн нэгж, иргэн тусгай зөвшөөрлөө авсны үр дүнд зорчигчдыг аюул, осолгүй тээвэрлэх нөхцөлийг бүрдүүлсэн байна. Албан шаардлагын биелэлт 89.2 хувьтай биелсэн.

Тав. Хяналт шалгалтаар илэрсэн нийтлэг зөрчлүүд

5.1 Автотээврийн хяналтын чиглэлээр:

- Автотээврийн хэрэгслийн техникийн ашиглалтын байдалд тавих шаардлагын дагуу техникийн хяналтын үзлэг (автотээврийн хэрэгслийн ерөнхий байдал, иж бүрдэл, хөдөлгүүр, хүч дамжуулах анги, тоормосны систем, жолооны механизм, гэрэл дохио, явах анги, экологи болон эргономикийн үзүүлэлт)-ийг бүрэн гүйцэд хийдэггүй;
- Тээврийн хэрэгслийн урд тэнхлэгийн хажуу гулсалт хэмжих тоног төхөөрөмжийн баталгаажуулалт хийдэггүй;
- Тээврийн хэрэгслийн холын болон ойрын гэрлийн тохиргоо алдагдсан;
- Тээврийн хэрэгслийн гэрлийн хүч нь стандартад заасан хэмжээ (10.000-225.000cd-кандел)-нээс хэтэрсэн, гэрлийн тусгал нь сарнисан, холын гэрлийн цайр нь бүдгэрсэн;
- Тээврийн хэрэгслийн гадна талын гэрэлтүүлэх хэрэгсэл бүрэн бус;
- Тээврийн хэрэгслийн гадна талд (урд болон хажуу талд) стандартад заагаагүй өөр төрлийн анивчсан (ягаан, ногоон, туузан лед) гэрэл суурилуулсан;
- Тээврийн хэрэгсэлд үйлдвэрлэгчээс тогтоосноос өөр замын хөдөлгөөний аюулгүй байдалд нөлөөлөх хурц тусгал бүхий (ксенон, лед) гэрэл суурилуулсан;
- Олон улс, улсын орон нутгийн авто замаар тээвэрлэлт гүйцэтгэж байгаа ААН нь тээвэрлэлтийн чиглэлийг батлуулаагүй, тээврийн хэрэгслийн бодит жингийн зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс (даац) хэтрүүлэн ачдаг;

- Орон нутгийн чанартай хөрсөн замаар ачаа даац хэтрүүлэн тээвэрлэлт хийж, олон салаа зам гаргаж, тоосжилт үүсгэдэг;
- Үйлдвэрлэснээс хойш 12-оос дээш (15-27) жил ашигласан 98, баруун талдаа жолооны хүрдтэй 33 автотээврийн хэрэгслээр жуулчин тээвэрлэлтийг зохион байгуулах, гүйцэтгэх гэрээ байгуулж, “Жуулчин таних тэмдэг” олгож, зорчигч тээврийн үйлчилгээ эрхэлсэн.

5.2 Авто замын хяналтын чиглэлээр:

- Авто замын барилгын ажилд ашиглаж буй карьерын газрын зөвшөөрөл, түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах гэрээг холбогдох хууль тогтоомжийн дагуу авдаггүй;
- Тухайн төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай ИТА, ажиллах хүн хүч, машин механизм ажлын талбай дээр байдаггүй;
- Чанарын хяналтын төлөвлөгөөнд техникийн шаардлагад заасан давтамжийн дагуу өдөр тутамд хийгдэх талбайн болон лабораторид хийгдэх нийт туршилт шинжилгээний тоо хэмжээний хувиарлалтын графикийг нэгж өдрөөр төлөвлөдөггүй;
- Барилга угсралтын ажлын явцад түр замын хөдөлгөөний зохион байгуулалтын зургийг гаргаж зөвлөх болон холбогдох мэргэжлийн байгууллагаар хянуулан баталгаажуулаагүй;
- Хариуцсан замын хүрээнд тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг үйл ажиллагаандаа тусгайлан төлөвлөж, хэрэгжилтийг хангуулан ажилладаггүй.

5.3 Төмөр замын хяналтын чиглэлээр:

- Вагоны техникийн паспортад засварын үнэлгээ, баталгааны тэмдэглэл хийдэггүй;
- Ашиглалтын хугацаа дууссан ачааны вагоны техникийн эрсдэлийн үнэлгээг гаргадаггүй;
- Төмөр замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой объектын гэрчилгээ аваагүй;
- Ачааны вагоны дахин ашиглалтын хугацааг 30 хувиас хэтрүүлсэн
- Төмөр замын тусгай бүсэд зөвшөөрөлгүй нэвтэрдэг, үйл ажиллагаа явуулдаг, галт тэрэгний хөдөлгөөнийг саатуулдаг тохиолдлууд түгээмэл гарч байна.

5.4 Усан замын хяналтын чиглэлээр:

- Усан замын тээвэрлэлт эрхлэх тусгай зөвшөөрөлгүйгээр үйл ажиллагаа эрхэлдэг.